

# ЖИРЭМСЭН ЭМЭГТЭЙД ГЕПАТИТИЙН Б ВИРУС ИЛЭРСЭН БОЛ ЭРҮҮЛ МЭНДЭЭ АНХААРАХ НЬ МАШ ЧУХАЛ

Танд ямар нэгэн шинж тэмдэг илрээгүй ч элэг гэмтэх, хорт хавдраар өвдөх эрсдэлтэй байдаг. Тогтмол үзлэг шинжилгээнд хамрагдаж, зохих эмчилгээ хийлгэснээр эрсдлийг бууруулж, хэвийн эрүүл амьдрахад тусална. Эмчээсээ дараах шинжилгээг лавлаарай.

Шинжилгээ	Хяналт	Шинжилгээний давтамж
АЛАТ	Элэгний эсийн гэмтэл	6-н сар тутам
АФП	Элэгний хавдарын маркер	6-н сар тутам
ГБВ ДНХ	Вирусийн ачаалал	Жилд 1 удаа
Эхо	Элэгний хавдар	6-н сар тутам



## ХЭРЭВ ШААРДЛАГАТАЙ БОЛ ВИРУСИЙН ЭСРЭГ ЭМЧИЛГЭЭГ ЭМЧИЙН ЗААВРЫН ДАГУУ ХИЙЛГЭХ

ГБВ-ийн халдвар эерэг илэрсэн хүн бүр вирусийн эсрэг эм уух шаардлагагүй. Хэрэв таны АЛАТ-ын түвшин өндөр ГБВ идэвхжилтэй бол вирусийн эсрэг эмийг уух талаар эмчээсээ лавлаарай. Ургамлын гаралтай зарим эм таны элгийг гэмтээх аюултай. Гэр бүлийн гишүүдээ ГБВ-ийн эсрэг дархлаатай эсэхийг шалгаж дархлаагүй бол вакцинд хамруулаарай.



## ГЕПАТИТИЙН А ВИРУСИЙН ВАКЦИНД ХАМРАГДАХ



## АРХИ СОГТУУРУУЛАХ УНДААНААС ТАТГАЛЗАХ



## ӨӨРИЙН ХАЙРТАЙ ХҮМҮҮСЭЭ ХАЛДВАРААС ХАМГААЛАХ

## ГБВ-ИЙН ЭСРЭГ ХАМТДАА



ГБВ-ийн эсрэг Jade Ribbon,  
JoinJade-ийн урианд нэгдэгтүн,  
Дэлхий даяараа ГБВ, элэгний  
хорт хавдрын эсрэг  
дуу хоолойгоо нэгтгэн тэмцье.



## Стэнфордын анагаах ухааны их сургуулийн дэргэдэх Азийн элэгний төв

780 Welch Road, CJ 130  
Palo Alto, CA 94304  
Tel: 888.311.3331  
Fax: 650.736.8001  
liver.stanford.edu  
#JOINJADE



## Халдварт өвчин судлалын үндэсний төв

Монгол улс, Улаанбаатар хот,  
Баянзүрх дүүрэг,  
Нам Ян Жүгийн гудамж  
Утас: 976-11-458699  
info@nccd.gov.mn  
www.nccd.gov.mn

©2025 АЗИЙН ЭЛЭГНИЙ ТӨВ



# ЭХЭЭС ХҮҮХДЭД ГБВ-ИЙН ХАЛДВАР ДАМЖИХААС СЭРГИЙЛЬЕ



## ГБВ БА ЖИРЭМСЭН ЭМЭГТЭЙН МЭДЭЭЛЭЛ

- ♥ ГБВ нь элгийг сонгомлоор гэмтээж элэгний хатуурал, хавдрын шалтгаан болдог.
- ♥ ГБВ-ийн халдвартай эхээс хүүхдэд төрлөгийн явцад дамжин халдварлана.
- ♥ Нярай үедээ ГБВ-ийн халдвар авсан тохиолдолд шинж тэмдэг илрэх нь бага ба 90% элэгний архаг халдварт шилжиж хатуурал, хавдрын суурь болдог.



### ТА ЖИРЭМСНИЙ ХЯНАЛТАНД ОРОХДОО ГБВ-ИЙН ШИНЖИЛГЭЭНД ЗААВАЛ ХАМРАГДААРАЙ

ГБВ-ийн архаг халдвартай хүнд шинж тэмдэг илэрдэггүй. Жирэмсэн эмэгтэй та хяналтанд орохдоо ГБВ-ийн шинжилгээнд хамрагдах. Үүнд:

**HBsAg:** ГБВ-ийн халдвартайг илэрхийлэх анхдагч үзүүлэлт. ГБВ-ийн цочмог ба архаг халдварын аль алинд нь цусанд илэрдэг. Таны шинжилгээ эерэг гарвал харьяаллын дагуу дотрын, халдвартын эмчид үзүүлж нэмэлт шинжилгээ, эмчилгээнд хамрагдах шаардлагатай.

## ГБВ-ИЙН ЭСРЭГ ВАКЦИН НЬ ДЭЛХИЙН АНХНЫ “ЭЛЭГНИЙ ХОРТ ХАВДРЫН ЭСРЭГ ВАКЦИН”



### ХЭРВЭЭ ТА ГБВ-ИЙН ХАЛДВАР АВААГҮЙ ЭСВЭЛ ДАРХЛААГҮЙ БОЛ ВАКЦИН ТАРИУЛААРАЙ.

ГБВ-ийн халдвар дамжих замууд

1. Халдвартай хүнтэй хамгаалалтгүй бэлгийн хавьталд орох
2. Эхээс урагт дамжин халдварлах
3. Халдвартай хүний цусаар дамжин халдварлах (сахлын хутга, шүдний сойз дундаа хэрэглэх, шивээсний зүү, чих цоолдог багаж дахин хэрэглэх).

ГБВ-ийн эсрэг вакциныг хийх нь үр дүнтэй, жирэмсний явцад ч тариулахад аюулгүй. Мөн уг вакцин нь гепатитийн делта вирусээс давхар хамгаална.



### ТА ХҮҮХДЭЭ ТӨРСНИЙ ДАРАА 24 ЦАГИЙН ДОТОР ГБВ-ИЙН ЭСРЭГ ВАКЦИН, ДАРААГИЙН ТУНГУУДЫГ ТОВЛОЛЫН ДАГУУ ХАМРУУЛААРАЙ

ГБВ-ийн вакцины бүрэн тун нь таны хүүхдийг халдвараас хамгаалж элэгний хатуурал, хавдрын эрсдлийг бууруулна.

ГБВ-ийн эсрэг вакциныг хүүхдэд төрсний дараа 24н цаг, 2,3,4 сартайд товллын дагуу тариулаарай.

## ЖИРЭМСЭН ЭМЭГТЭЙ ТА ГБВ-ИЙН ХАЛДВАРТАЙ БОЛ ДАРААХ ЗҮЙЛСИЙГ АНХААРНА УУ



### ЖИРЭМСНИЙ ЯВЦАД:

Өөрийгөө хамгааларай. Эмчээсээ элэгний гэмтэл, ГБВ ДНХ-ийн түвшин, АЛАТ цусны шинжилгээнд хяналт тавьж, хэрэв шаардлагатай бол нарийн мэргэжилтэнрүү дэлгэрэнгүй үнэлгээнд илгээхийг санал болгоорой. Жирэмсэн эмэгтэй таны ГБВ ДНХ түвшин 200,000 IU/ml ээс дээш өндөртэй бол тенофовир вирусийн эсрэг эмчилгээг эхээс хүүхдэд дамжих ГБВ-ийн эсрдэлийг бууруулах зорилгоор жирэмсний 28 дахь долоо хоногоос эхлэн хийлгэхийг зөвлөж байна.

ГБВ-ийн халдвар нь хөхний сүүгээр дамжин халдварлах нь маш ховор. **Кесаров хагалгаа** хийлгэснээр ГБВ-ийн халдвар эхээс хүүхдэд дамжихаас сэргийлэхгүй.



### ХҮҮХДЭЭ ТӨРСНИЙ ДАРАА ТА ЮУГ АНХААРАХ ВЭ?

ГБВ-ийн халдвартай эхээс төрсөн хүүхдэд төрснөөс хойш 12 цагийн дотор ГБВ-ийн эсрэг вакцины эхний тун болон ГБВ-ийн эсрэг иммуноглобулинийг (HBIG) зааврын дагуу нэг өдөр зэрэг тариулж хүүхдэд халдвар дамжихаас сэргийлэх шаардлагатай төдийгүй вакцины бүрэн тунг товллын дагуу хийлгэх шаардлагатайг онцгойлон анхаарна уу.

Нярайд бүрэн вакцин хийснээс хойш 1-2 сарын дараа ГБВ-ын халдвараас хамгаалах дархлаа тогтсон эсэхийг шалгуулаарай. Хэрэв вакцины дараа дархлаа тогтоогүй бол хүүхдүүдэд вакцины нэмэлт тунг тарьж болно.